

Харилцагчийг таньж мэдэх арга, эцсийн өмчлөгч

Санхүүгийн мэдээллийн алба



Харилцагчийг таньж мэдэх

ХТМ гэдэг нь

- харилцагчийг тодорхойлох мэдээллийг харилцагчаас гаргуулж авах бөгөөд
- хэнийг төлөөлж байгаа,
- ямар үйл ажиллагаа явуулдаг,
- ямар зорилгоор харилцаж байгаа зэрэг мэдээллийг тодруулах,
- тухайн мэдээллийн үнэн зөвийг тогтоох зорилгоор албан ёсны бичиг баримт, төрийн байгууллагын мэдээллийн сан болон мэдээллийн бусад эх үүсвэрийг ашиглан мэдээллийг баталгаажуулах үйл ажиллагааг хэлнэ.

01.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль

02.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам

Харилцагчийн болон түүний төлөөлж байгаа этгээдийн өмчлөлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага, бизнесийн байгууллагын үйл ажиллагаа эрхэлдэг этгээд, удирдах эрх бүхий этгээдийг тодорхойлох, мэдээллийг баталгаажуулах **зорилготой** юм.

МУТС аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх

Бүтээгдэхүүнийг нь ашиглан гэмт хэргээс үйлдэхээс зайлсхийх

Сэжигтэй гүйлгээ болон үйлдлийг илрүүлэх

Ямар тохиолдолд харилцагчийг таньж мэдэх арга хэмжээ авах?

- Бизнесийн харилцаа тогтооход;
- Тохиолдлын чанартай 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй гүйлгээ хийхийн өмнө;
- 24 цагийн дотор хийсэн, хоорондоо холбоо бүхий хэд хэдэн удаагийн гүйлгээний нийт үнийн дүн нь 20 сая төгрөг түүнээс дээш үнийн дүнтэй бол;
- Харилцагчийн талаар өмнө авсан мэдээллийн үнэн зөв эсэхэд эргэлзсэн тохиолдолд;
- Тухайн харилцагч, гүйлгээг МУТС үйл ажиллагаатай холбоотой гэж сэжиглэсэн тохиолдолд.



Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа явуулахдаа:

- Харилцагчийг хэн болохыг тогтоож, баталгаажуулах;
- Эцсийн өмчлөгчийг тогтоох;
- Бизнесийн харилцааны зорилго, мөн чанарыг ойлгох;
- Бизнесийн харилцааг тогтмол нягтлах, гүйлгээнүүдэд нарийвчилсан дүн шинжилгээ хийх;
- Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг тогтмол явуулах.

Харилцагч шаардсан мэдээллийг өгөхөөс татгалзвал түүнд үйлчилгээ үзүүлэхээс татгалзах үүрэгтэй.

ИРГЭН

- Овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр
- Төрсөн он, сар, өдөр
- Иргэний үнэмлэхийн, эсхүл гадаад паспортын хуулбар (хуулбарыг эх хувьтай нь тулгана)
- Баримт бичгийг шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар.

ХУУЛИЙН ЭТГЭЭД

- Нэр
- Оршин байгаа газрын хаяг
- Улсын бүртгэлийн болон татвар төлөгчийн дугаар
- Харилцах утасны дугаар
- Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар (хуулбарыг эх хувьтай нь тулгана)
- Баримт бичгийг шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар
- Удирдлагын талаарх дэлгэрэнгүй танилцуулга.

Эцсийн өмчлөгчийн нэрийн өмнөөс данс нээж, гүйлгээ хийж байгаа эсэхийг мэдэх, ойлгох

- Тухайн бизнесийн харилцааны зорилго
- Гүйлгээний утга
- Эцсийн хүлээн авагчийн тухай мэдээллийг тодруулах

Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг тодорхойлох

- Эцсийн өмчлөгчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр
- Эцсийн өмчлөгчийн талаар болон харилцагчийн өмчлөл, хяналт, зохион байгуулалтын бүтцийг таньж мэдэх

Харилцагч нь хуулийн этгээд, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгч бол

- Түүний нэрийн өмнөөс харилцах этгээд нь тийм эрхтэй эсэхийг нягтлах
- Уг этгээдийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийг тодорхойлох
- Баримт бичигтэй нь тулгаж шалгах

ИРГЭН

- Овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр
- Төрсөн он, сар, өдөр
- Регистрийн дугаар
- Оршин суудаг газрын хаяг, холбоо барих утасны дугаар
- Эрхэлж буй ажил, бизнес:
 - Бизнесийн чиглэл, цар хүрээг тодруулах
 - Ажлын газрын нэр, хаяг, албан тушаалыг тодруулах
- Өөр хэн нэг этгээдийг төлөөлөн данс нээлгэж, гүйлгээ хийж байгаа эсэхийг тодруулах

ХУУЛИЙН ЭТГЭЭД

- Нэр
- Улсын бүртгэлийн дугаар
- Регистрийн дугаар
- Хувьцаа эзэмшигчид
- Үйл ажиллагааны чиглэл
- Хуулийн этгээдийн хувьцаа эзэмшлийн бүтэц
- Хуулийн этгээдийн удирдлагын талаарх дэлгэрэнгүй танилцуулга
- Хаяг, холбоо барих утасны дугаар
- Эцсийн өмчлөгчийн мэдээлэл




Хуулийн этгээдийг төлөөлж байгаа бол

МҮЭ нь харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаанд байнга хяналт тавьж, харилцагчийн болон эцсийн өмчлөгчийн талаарх мэдээллийг бизнесийн харилцааны туршид цуглуулж, хадгална.

МҮЭ нь дараах тохиолдолд харилцагчийн мэдээллийг дахин тулгаж шалгана.

1. Өндөр дүнтэй гүйлгээ хийх гэж байгаа тохиолдолд;
2. Дансыг ашиглаж байсан байдалд өөрчлөлт гарсан тохиолдолд;
3. Өмнө нь авсан харилцагчийн мэдээлэл нь МҮЭ-д санхүүгийн харилцаа болон гүйлгээний шинж чанар, зорилгыг ойлгож тодорхойлоход хангалтгүй байвал.



Зөвлөмж 11 – СБ нь ХТМ үйл ажиллагаагаар бүрдүүлэн авсан дансны баримт, материалууд, бизнесийн харилцаанаас үүдэлтэй бүх бичилт болон дүн шинжилгээний дүгнэлтийг, бизнесийн харилцаа дууссанаас хойш эсвэл зарим тохиолдлын гүйлгээ хийгдсэнээс хойш хамгийн багадаа 5 жилийн хугацаанд хадгалах шаардлагатай.

Зөвлөмж 12 – СБ нь Зөвлөмж 10-т заасан ХТМ-ээс гадна гадаадын улс төрд нөлөө бүхий этгээдтэй холбоотой арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай.

Зөвлөмж 13 - Корреспондент банкны дансанд шууд холбогддог өөрийн харилцагчийн талаар ХТМ үүргийг хэрэгжүүлэх

Зөвлөмж 17 – Бизнесийн харилцаа эхлэхдээ гуравдагч санхүүгийн байгууллага ба СББМҮҮ-д тулгуурлахаар бол ХТМ арга хэмжээний эцсийн хариуцлага нь гуравдагч этгээдэд түшиглэж байгаа тухайн санхүүгийн байгууллагад ногдох бөгөөд уг байгууллага холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Зөвлөмж 18 – ХТМ болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн удирдах зорилгоор мэдээлэл солилцох бодлого, журамтай байна;

Харилцагчийн таньж мэдэх үйл ажиллагаа

Харилцагчийг таньж мэдэх хэвийн үйл ажиллагаа

Бүх харилцагчид

Харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагаа

Өндөр эрсдэлтэй харилцагчид

Харилцагчийг таньж мэдэх хялбаршуулсан үйл ажиллагаа

Бага эрсдэлтэй харилцагчид

Эрсдэлийн үнэлгээ болон Үндэсний эрсдэлийн үнэлгээгээр өндөр эрсдэлтэй гэж үнэлэгдсэн

- 5.9.1.УТНБЭ;
- 5.9.2.МУТСТ чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас МУТСТ хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж зарлагдсан улсын хүн, хуулийн этгээд;
- 5.9.3.МУТСТ үндэсний эрсдэлийн үнэлгээгээр өндөр эрсдэлтэй гэж үнэлэгдсэн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа хүн, хуулийн этгээд.

- 6.1.1.огцом өөрчлөгдсөн их дүнтэй;
- 6.1.2.эдийн засаг, хууль зүйн илт үндэслэлгүй;
- 6.1.3.УТНБЭ-ийн нэр дээр хийсэн;
- 6.1.4.МУТСТ чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас МУТСТ хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж тодорхойлогдсон улсаар дамжуулан хийсэн.



Ажил, бизнес, хөрөнгийн эх үүсвэр, гүйлгээний зориулалт, утга зэрэгтэй холбоотой нэмэлт мэдээллийг гаргуулж авах, мэдээллийн үнэн бодит байдлыг нягтлах;

Тухайн харилцагчтай бизнесийн харилцааг цаашид үргэлжлүүлэх эсэх талаар Гүйцэтгэх удирдлагын зөвшөөрлийг авна;

Харилцагчийн данс, гүйлгээнд тавих хяналт давтамжийг нэмэгдүүлэх, хяналтын цар хүрээг өргөжүүлэн харилцаж байгаа бусад этгээдийг хяналтад хамруулах, харилцагчийг таньж мэдэх зорилгоор харилцагчаас гаргуулан авах мэдээллийг эргэж хянах;

ХТМ нарийвчилсан үйл ажиллагаатай холбоотой бусад журам, зааврын шаардлагууд.

ХТМ нарийвчилсан үйл ажиллагааг өндөр эрсдэлтэй харилцагчид бүтээгдэхүүн, үйлчилгээ авах бүрт нь холбогдох нэмэлт мэдээллийг авах, өмнө нь өгсөн мэдээлэлд гарсан өөрчлөлтийг тусгах замаар байнгын үргэлжлэх хэлбэрээр хэрэгжүүлнэ.

Харилцагчийг тодорхойлох мэдээлэлд орсон өөрчлөлтийг шинэчлэх давтамжийг багасгах,

Гүйлгээнд тавих байнгын хяналт тавих болон гүйлгээтэй холбоотой нэмэлт мэдээлэл цуглуулах түвшинг бууруулах

Харилцагч, эсхүл гүйлгээг МУТС холбоотой гэж сэжиглэсэн эсхүл МҮЭ, хяналт шалгалтын чиг үүрэгтэй эрх бүхий байгууллага, СМА-наас өндөр эрсдэлтэй гэж үзсэн бизнес, улс оронтой холбоотой харилцагчид харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг хялбаршуулсан байдлаар хийхгүй.

Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаанд байнга хяналт тавьж, харилцагчийн болон эцсийн өмчлөгчийн талаарх мэдээллийг бизнесийн харилцааны туршид цуглуулж, хадгална.

ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧ ГЭЖ ХЭН БЭ?

Харилцагч нь **хуулийн этгээд бол** тухайн хуулийн этгээдийн хөрөнгийн дийлэнх хэсгийг дангаараа, эсхүл бусадтай хамтран өмчилж байгаа, эсхүл тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааг удирдан чиглүүлж, эсхүл өөрийн үйлдлийг бусдаар төлөөлүүлэн хийлгэж байгаа, эсхүл хуулийн этгээдийг болон уг хуулийн этгээдээс хийх аливаа хэлцэл, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдах замаар тухайн хуулийн этгээдийг өмчилж үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүнийг;



Харилцагч нь **хувь хүн бол** тухайн хүний үйлдэл, үйл ажиллагааг удирдан чиглүүлж, эсхүл тухайн хүнээр өөрийн үйлдлийг төлөөлүүлэн хийлгэж үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүнийг;



Хөрөнгийг удирдах хэлцлийн хувьд тухайн хөрөнгө итгэмжлэн удирдах хэлцлийн үндсэн дээр үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүнийг.



Яагаад эцсийн өмчлөгчийг тодорхойлох нь чухал вэ?

Эцсийн өмчлөгчийг нууцлах нь татвараас зайлсхийх, авлига, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн үйл ажиллагаа явуулах боломжийг улам нэмэгдүүлдэг.




Эцсийн өмчлөгчийн мэдээллийг ямар байдлаар нуун далдалдаг вэ?



- Халхавч компани;
- Нарийн төвөгтэй өмчлөл, удирдлагын тогтолцоо
- Эзэмшигчийн хувьцаа (bearer share) болон эзэмшигчийн хувьцааны баталгаа (Bearer share warrant);
- Хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага, захирлын эрх хэмжээнд хязгаар тогтоохгүй байх;
- Албан ёсны нэрлэсэн хувьцаа эзэмшигч болон нэрлэсэн удирдлагатай хуулийн этгээд (nominee shareholder and directors);
- Траст болон үүнтэй төстэй бусад хуулийн зохицуулалт бүхий этгээд;
- Хуулийн этгээдийг байгуулах болон үйл ажиллагааг эрхлэхэд компанийн зуучлалын үйлчилгээг ашиглах г.м






Мэдээлэх үүрэгтэй этгээд нь харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааны дагуу эцсийн өмчлөгчийг тогтоохдоо хамгийн багадаа доор дурдсан шат дараалсан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.


- Харилцагчаас эцсийн өмчлөгчийн мэдээллийг нь тодорхойлуулж гаргаж авах;
- Харилцагчийн гаргаж өгсөн мэдээллийн дагуу холбогдох бичиг баримтыг гаргуулан авах;
- Харилцагчийн гаргаж өгсөн мэдээлэл, түүнд холбогдох бичиг баримтын үнэн зөвийг албан ёсны мэдээ, мэдээллийн эх үүсвэр ашиглан баталгаажуулан шалгах /Улсын бүртгэлийн байгууллагын мэдээллийн сангаас баталгаажуулах/

3.1.Компанийн эцсийн өмчлөгчийг тогтоох нь

Зураг 1




Зураг 2



3.2.Компаниас бусад хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг ТОГТООХ НЬ

- Төрийн бус байгууллага, Шашны байгууллага, Сан, Үйлдвэрчний эвлэл зэрэг ашгийн бус байгууллагын эцсийн өмчлөгчийг тодорхойлохдоо тухайн байгууллагын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, зохион байгуулах, гол шийдвэрийг гаргах эрх бүхий дор дурдсан хүнийг тодорхойлно.
 - Удирдах зөвлөлийн дарга, удирдах зөвлөлийн гишүүн;
 - Дээрх этгээд байхгүй бол гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн;
 - Дээрх этгээд байхгүй бол үүсгэн байгуулагч хувь хүн;
 - Үүсгэн байгуулагч нь өөр нэг хуулийн этгээд бол тухайн хуулийн этгээдийн төрлөөс хамаарч эцсийн өмчлөгчийг хувь хүн хүртэл тогтооно.



3.2.Компаниас бусад хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг ТОГТООХ НЬ

- Нөхөрлөлийн (Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл, бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл, зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл) хувьд эцсийн өмчлөгч нь тухайн нөхөрлөлийн саналын эрхийн дийлэнхийг эзэмшиж байгаа гишүүд, эсвэл нөхөрлөлийн гэрээнд заасны дагуу удирдах, төлөөлөх эрх бүхий гишүүдийг эцсийн өмчлөгчөөр тооцно.
- Хоршоо болон Хадгаламж зээлийн хоршооны хувьд эцсийн өмчлөгч нь тухайн хуулийн этгээдийн тэргүүлэгчид, дарга, гүйцэтгэх захирал, эсхүл эдгээр удирдах түвшний этгээд байхгүй бол 33 хувиас дээш хувийг эзэмшиж буй хоршооны гишүүдийг эцсийн өмчлөгчөөр тодорхойлно.



3.2.Компаниас бусад хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг ТОГТООХ НЬ

- Гадаад улсад бүртгэлтэй болон дотоодын хөрөнгө оруулалтын сангийн 33 хувиас дээш хөрөнгийг оруулсан хувь хүнийг эцсийн өмчлөгчөөр тодорхойлно.
- Хөрөнгө оруулалтын сан нь хөрөнгө оруулалтын менежментийн компанийн удирдлаган дор үйл ажиллагаа явуулж байгаа бол тухайн ХОМК-ийн 33 хувиас дээш хувьцааг эзэмшиж буй хувь хүнийг эцсийн өмчлөгчөөр тодорхойлно.
- Траст буюу гэрээний үндсэн дээр үйл ажиллагаа эрхлэгчийн эцсийн өмчлөгчийг тогтоохдоо тухайн трастыг шууд болон шууд бусаар удирдаж байгаа эсхүл ашиг шимийг хүртэгч этгээдийг тодорхойлох шаардлагатай. Үүнд: сетлор, трастий, хамгаалагч (хэрэв байгаа бол), үр шим хүртэгчийн талаар үнэн зөв бодитой мэдээллийг тодорхойлох.



Хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрын улсын бүртгэл хөтлөх журмын дагуу:

Хууль зүй, дотоод хэргийн сайдын
2018 оны А/208 дугаар тушаалын хавсралт

Зургаа¹.Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийн улсын бүртгэл хөтлөх

6¹.1.Улсын бүртгэгч Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6-д заасан хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч /цаашид “эцсийн өмчлөгч” гэх/-ийн мэдээллийн улсын бүртгэл хөтлөхөд энэ журмын Зургаа¹ дугаар зүйлд заасныг баримтална.

6¹.2.Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан захиргааны байгууллагын улсын бүртгэл хөтлөхөд энэ журмын Зургаа¹дугаар зүйл хамаарахгүй.

6¹.4.Энэ журмын 6¹.3-т заасан өргөдөлд дараах баримт бичгийг хавсаргана:

6¹.4.1.эцсийн өмчлөгч нь гадаадын иргэн бол паспортын хуулбар;

6¹.4.2.үргэлжилсэн хэлхээ холбоо бүхий гадаадын хуулийн этгээд бол тухайн улсын эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан хуулийн этгээдийн гэрчилгээний хуулбар, түүний орчуулгын баталгаажуулсан хувь.

3.3.Өөр хүний өмнөөс гүйлгээ хийж байгаа этгээдийн эцсийн өмчлөгчийг тогтоох нь

Тухайн данс нээлгэх болон гүйлгээг төлөөлүүлэн хийлгэж үр шим, ашиг орлогыг хүртэж буй жинхэнэ цаад эзэн нь хэн бэ гэдгийг заавал тодорхойлно.

Хөрөнгийг удирдах хэлцлийн үндсэн дээр харилцагчийн нэрийн өмнөөс түүнийг хөрөнгийг ашиглах, эзэмших, захиран зарцуулах эрхтэй этгээд (хуульч, нотариатч, үл хөдлөх хөрөнгийн зуучлагч гэх мэт) төлөөлж буй тохиолдолд тухайн хөрөнгө итгэмжлэн удирдах хэлцлийн үндсэн дээр үр шим, ашиг орлогыг хүртэж буй хүнийг заавал тодорхойлно.

Хэрэв мэдээлэх үүрэгтэй этгээд нь данс нээж бизнесийн харилцаа тогтоохоос өмнө нэг удаагийн шинжтэй тохиолдлын гүйлгээ хийх үед тухайн гүйлгээг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэж сэжиглэж байгаа тохиолдолд нэг удаагийн харилцагч гэдгээс үл хамааран харилцагч болон эцсийн өмчлөгчийг хэн болохыг тогтоож, баталгаажуулах арга хэмжээг авдаг байх шаардлагатай.

3.4. Улс төрд нөлөө бүхий этгээд болон бусад өндөр эрсдэлтэй харилцагч

- Хувьцаа эзэмшигч нь улс төрд нөлөө бүхий этгээд бол эзэмшлийн хувь хэмжээ харгалзахгүйгээр эцсийн өмчлөгч гэж үзнэ.
- Мэдээлэх үүрэгтэй этгээд нь НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс болон дотоодын эрх бүхий байгууллагаас тодорхойлсон террорист этгээд болон санхүүгийн хориг арга хэмжээний жагсаалтанд орсон иргэн хуулийн этгээдтэй харилцаа тогтоож бизнесийн харилцаа үүсгэхийг хориглосон байдаг.

МЭДЭЭЛЛИЙГ БАТАЛГААЖУУЛАХДАА:

- Хуулийн этгээдийн гэрчилгээ, дүрэм;
- Хувьцаа эзэмшигчдийн гэрээ;
- Нөхөрлөлийн гэрээ;
- Трастын гэрээ;
- Хуулийн этгээдийн дээд удирдлага, ТУЗ, гүйцэтгэх удирдлагын мэдээлэл;
- Эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн гэрчилгээ;
- Хуулийн этгээдийн санхүүгийн тайлан;
- Улсын бүртгэлийн ерөнхий газраас олгосон лавлагаа;
- Хөрөнгийн биржийн нээлттэй мэдээлэл;
- Эцсийн өмчлөгч хувь хүн тус бүрийн иргэний үнэмлэх, гадаад паспорт эсхүл түүнтэй адилтгах бусад биеийн байцаалт;
- Гадаад улсад бүртгэлтэй хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг тодорхойлох, баталгаажуулах зорилгоор гадаад улсаас ирүүлсэн бичиг баримтын хүчинтэй байдлыг хангах зорилгоор нотариатаар баталгаажуулах, апостилоор гэрчлүүлэх шаардлага тавьж болох боловч үүнийг эрсдэлд суурилсан аргачлалаар хэрэгжүүлэх;
- Найдвартай, албан ёсны, хараат бус мэдээллийн бусад эх үүсвэр.



**Анхаарал хандуулсан
танд баярлалаа**